

Хүн амын байршил, шилжих хөдөлгөөн ба нийгэм эдийн засгийн харилцан нөлөөлөл

А. Амарбал

МУИС-ийн Хүн Ам Зүйн Сургалт

Судалгааны Төвийн магистрант

Хүн амын байршил, шилжих хөдөлгөөний нийгэм эдийн засаг дахь нөлөөлөл, нөгөө талаас нийгэм эдийн засаг нь хүн амын байршилт, шилжих хөдөлгөөндөө хэрхэн нөлөөлөх вэ гэдгийг харгалзан үзэж, цаашид ямар арга замаар харилцан хамаарлыг зохицуулах боломжтой вэ гэдэгт хариулт өгөх нь энэ өгүүллийн зорилго болсон.

Хүн амын байршлын хувьд нийгэм эдийн засагт

хэрхэн нөлөөлөх вэ

Хөдөлмөрийн нөөцийн хувиарлалт, ашиглалтад:

Хүн амын байршилт нь тухайн улсын газар нутаг, нийгэм эдийн засгийн хөгжил, эрхэлж буй аж ахуй, үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан харилцан адилгүй нягтшилтай байдаг. Энэ нь хөдөлмөрийн нөөц хувиарлалтад шууд нөлөөлдөг. Жишээ нь хөдөлмөрийн нөөц дутагдалтай газар ажлын байрны илүүдэл гарснаас капиталын нөөцийг бүрэн ашиглаж чадахгүй байхад үүнтэй хамт мэргэжлийн боловсон хүчнүүд мэргэжлийн ажлаа эрхлээгүйгээс бүрэн бус ажил эрхлэлт буй болдог энэ нь мөн эдийн засгаас алдагдаж буй боломж юм. Гэтэл өөр нэг мужид (Аймагт) хөдөлмөрийн нөөцийн илүүдэл гарснаар ажилгүйдэл бий болдог улмаар энэ нь ядууралд хүргэдэг. Үүнээс үүдэн нийгмийн халамжийг нэмэгдүүлэх шаардлага буй болгоно. Мөн хөдөлмөр эрхлэлт багатай байх нь гэмт хэргийг ихэсгэх хортой үр нөлөөтэй байдаг.

Засаг захиргааны нэгжийн хувиарлалтанд:

Хүн амын байршлаас шалтгаалан засаг захиргааны нэгжийн хувиарлалтыг зөв хийх хэрэгтэй юм. Жишээ нь хүн амын тоо онцлогыг харгалзалгүй засаг захиргааны нэгжийг хувирласнаар зарим хэсэгт нь их хүн амтай бага газар нутагтай нэгжүүдийг буй болгох энэ нь үргүй зардлыг бий болгодог. Газар нутаг нь том, хүн амын тоо цөөтэй мужид явуулж буй арга хэмжээ нь хүрэлцээ муутайгаас хэт төвлөрөлтийг урамшуулах шалтгаан болж өгөх талтай.

– Газар нутгийн бүрэн ашиглалт,

(Газар нутгийн бүрэн бүтэн байдал):

Хүн ам нь хэт төвлөрснөөс алслагдсан муж хэсэгт хүнгүйдэх энэ нь улмаар тус бүс нутгийн нийгмийн хөгжилд анхаарал хандуулах шаардлагыг тавина. Энэ нь эдийн засагт үргүй зардлыг нэг талаас шилжилт бий болгосноор эхлээд хувь хүмүүс, нөгөө талаар улсад тэр хэсэгт хөрөнгө оруулалтыг буй болгосноор гарч ирдэг. Энэ зардлуудыг гаргахгүй байх арга зам хэрэгтэй юм. Мөн энэ /алслагдсан/ байгаль, экологийн нөөцийг ашиглах боломжийг алддаг. /Малын бэлчээр/

Хэт алслагдсан байдал ч хүн амын нийгмийн асуудлуудад хүндрэл учруулдаг. Иймээс зохистой байршил чухал юм.

Нийгэм эдийн засаг нь хүн амын байршилдаа хэрхэн нөлөөлөх вэ

Үүнд анхаарах зүйл бол нийгэм эдийн засгийн бодлого, авч явуулж буй арга хэмжээнүүдийн үр дүнгээр хүн амын байршилтын дахин хуваарилалтыг шилжих хөдөлгөний тусламжтайгаар авч явуулдаг.

Аль нэг бүс нутаг хотын нийгмийн асуудлыг зөв шийдэх нь хүн амыг тэр чиглэлд татах хүч болдог энэ нь улмаар хүн амынхаа байршилтыг өөрчлөн нийгэм эдийн засгийн нөхцлөө хүндрүүлдэг. Мөн нийгэм эдийн засгийн нөхцлийг нь хүндрүүлснээр тэр бүсэд амьдрах боломжгүй болж, тухайн бүсээс түлхэх шалтгаанаар шилжих шилжилт ихэссэнээр хүн амын байршлыг өөрчилдөг (тодорхой хугацаанд). Мөн хөрөнгө оруулалтыг буруу хувиарласнаар нийгмийн үйлчилгээний тэгш биш байдал хүн амын байршлыг дахин хувиарилдаг. Цалин хөлсний ялгаа ч дээрх өөрчлөлтөнд хүргэнэ.

Энэ бүгдийг зохицуулдаг хүч бол хүн амын шилжих хөдөлгөөн юм. Нөгөө талаар шилжих хөдөлгөөн ч нийгэм эдийн засгийн нөлөөллөөс бий болоод эргээд шилжих хөдөлгөөн нь нийгэм эдийн засгийн нөхцөл байдалд хоёр талтайгаар нөлөөлнө.

Шилжих хөдөлгөөнд нөлөөлж буй нийгэм эдийн засгийн нөлөөллийг шууд болон шууд бус арга замаар явуулдаг. Гол шууд арга замууд нь тэр болгон амжилтай байдаггүй гэж судлаачид үздэг.

Харин шилжих хөдөлгөөн нь хүн ам зүйн үзүүлэлтүүдээс биологийн хүчин зүйлээс шалтгаалал багатай нь юм. Гэхдээ тэр болгон тэгэж үзэж болохгүй хэд хэдэн шалтгаан байдаг. Үүнд насны болон хүйсийн, хувь хүний өөрийн сонирхол шалтгаалах явдал байдаг гэж дээр хэлсэн. Тухайн шилжигчийн гэрлэлтийн байдал шилжих хөдөлгөөн оролцоход нөлөөлөх бас нэг хүчин зүйл болдог. Хувь хүний боловсролын түвшин шилжих хөдөлгөөнд оролцоход нөлөөлөх бас нэг хүчин зүйл болдог. Хувь хүний боловсролын түвшин шилжих хөдөлгөөнд оролцоход нөлөөлдөг хүчин зүйлүүдийн нэг юм. Жишээ нь залуучууд шилжих хөдөлгөөнд их оролцдог нь хувийн болон насны нөлөөллөөс шалтгаалдаг байхад, өндөр настай хүмүүс буцах шилжилтэнд илүүтэйгээр оролцдог. Хүйсийн хувьд эрэгтэйчүүдийн шилжилт түрүүлж, хэсэг хугацааны дараа эмэгтэйчүүдийн шилжилт ихэссэнээс урт хугацаандаа тэнцвэржих хандлагатай юм. Гэрлээгүй хүмүүс гэр бүлтэй хүмүүсийг бодвол илүү шилжилтэнд оролцдог нь шилжилтэнд зориулагдах зардал харьцангуй бага байдагтай холбоотой юм. Боловсролын түвшин дээшлэх тусам шилжих хөдөлгөөнд оролцох хэмжээ нь ихэсдэг.

Тэгвэл нийгмийн хүчин зүйлээс шилжих хөдөлгөөнд ямар хүчин зүйлүүд хэрхэн нөлөөлж байдаг вэ гэдгийг авч үзье.

Хууль тогтоомж: Тухайн бүс, улсын бодлогод хүн амын шилжих хөдөлгөөнийг хэрхэн тусгасан болон бусад мөрдөгдөж буй хууль

тогтоомж нь хувь хүмүүсийн ашиг сонирхолд нийцсэн эсэх нь шилжих хөдөлгөний урсгалыг түлхэх болон татах шалтгаанд хүргэдэг.

—Цалин хөлсний / орлогын / ялгаа: Энэ хүчин зүйл нь хувь хүний ашиг сонирхолтой ихээхэн холбоотойгоор шилжих хөдөлгөөнд нөлөөлдөг. Хаана ижил хөдөлмөр эрхлээд илүү цалин авч байна тэнд ажиллах сонирхлыг хүмүүст илүүтэйгээр төрүүлдэг. Үүний улмаас шилжих хөдөлгөөнийг жолоодох арга зам нь болж өгч болдог.

— Ажил олох боломж, орлого нэмэгдүүлэх боломж : Ажил олгох боломж гэдэг нь хүмүүс тэр болгон өөрийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлж байдагтай холбоотой. Мөн шинээр үйдвэрлэл эрхлэхэд зах зээл ямар түвшинд хөгжсөн вэ гэдгээс ихээхэн шалтгаалах нь зүй ёсны хэрэг, энэ нь муу байвал тухайн үйлдвэрлэгчид орлого нэмэгдэх боломж хязгаарлагдмал байгаагаас шилжих хөдөлгөөнд оролцох зах зээлийн боломжтой газарт очих сонирхлыг төрүүлнэ.

Нийгмийн үйлчилгээний чанар: Үүнд бүхий л үйлчилгээ орно. Орон байрны, Эрүүл мэнд, Эрчим хүч, Тээвэр холбоо, Мэдээлэл, Худалдаа, боловсрол шинжлэх ухааны / нийгмийн халамж/ гэх зэрэг бүхий л үйлчилгээ нь жигд сайн байж сая хүмүүсийн тогтвортой байлгах, улмаар шилжих хөдөлгөөний урсгалыг татах боломжтой болдог.

— Оршин амьдарч байгаа бүс, хотын ирээдүйн боломж

/Хөрөнгө оруулалт / : Хэн ч ирээдүйд цаашид амьдрах нөхцөл байдлаа илүүтэйгээр хардаггүй ч тодорхой хэмжээгээр энэ нь шилжих хөдөлгөөнд оролцогчийн харгалзаж үздэг үзүүлэлтүүдийн нэг. Жишээ нь: Цаашид тухайн бүс нутагт амьдарснаар хүүхдийнхээ боловсролыг дээшлүүлэх боломж муутай юм гэж үзэх нь энэ бүс нутагт боловсролын систем муу хөгжсөн аль эсвэл уналтад орж буй, хөрөнгө оруулалт бага байгаагаас боловсон хүчнээ алдсан гэж үзэж болох талтай.

Хувь хүний болон нийгэм эдийн засгийн хүчин зүйлүүд нь харилцан шилжих хөдөлгөөн, нийгмийн асуудлын шалтгаан болно гэж үзэж болохгүй юм. Үүнд: гурав дахь нөлөөлөгч нь газар зүй байгаль, экологи байдаг. Шилжих хөдөлгөөний чиглэлийг тодорхойлох гол үндэс болдог.

— Газар зүйн байршилт

— Ган, зуд


— Байгаль экологийн эрүүл ахуй

Дээрх харилцан нөлөөллүүдийн нийлбэр дээр шилжигч шийдвэр гаргаснаар нийгэм эдийн засгийн болон хувь хүний сонирхол зохицогдож байдаг. Үүнд 2 сонирхолыг нийцүүлснээр шилжих хөдөлгөөнийг зөв зохион байгуулах, хүн амын байршилтыг зөв хариулах зорилго биелнэ. Тэгэхлээр харилцан хамаарлыг зөв тодорхойлох зэрэг үр дагавар багатай арга замыг сонгох нь зүйтэй юм.

Хүн амын байршилт, шилжих хөдөлгөөн ба нийгэм эдийн засгийн харилцан нөлөөллийг хялбаршуулан харуулах мөн үүн дээрээ тулгуурлан зохицуулах бодлогыг хаана нь хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй

вэ гэдгийг тайлбарлахад тулгуур болгосон. Шилжих хөдөлгөөнөөр хүн амын байршилтыг зөв хувиарилна гэдэг нь дээрх харилцан хамаарлын аль хэсэгт ямар арга зам хэрэглэснээс ихээхэн шалтгаална. Шилжих хөдөлгөөнийг зохицуулахдаа шууд ба шууд бус аргуудыг ашиглана. Ихэвчлэн шууд бус арга замуудыг ашиглах нь илүү үр дүнтэй байдаг.

Өнөөдөр манай орны хувьд хүн амын зохистой байршилыг хангах нь ирээдүйн хөдөлмөрийн нөөцийн зөв хувиарлалтаар, хөдөлмөрийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх, нэгэнт бүрэлдсэн нөөцийг бүрэн ашиглах боломж олгох үндсэн нөхцөл нь хүн амын дотоод шилжих хөдөлгөөн гэж үзэж одооноос бодлого авч явуулж буй арга хэмжээндээ хүн амын байршил дахь өөрчлөлтөд хэрхэн нөлөөлөх вэ гэдгийг сайтар анхаарах хэрэгтэй юм.



Дээрхээс үндэслэн цаашид хэрэгжүүлж болохуйц саналуудыг:

– Хүн амын байршилтанд судалгаа хийх шаардлагтай

- Шилжих хөдөлгөөний мэдээллийг чанаржуулах, одоо авч буй маягт / ХААТР-22, ХААТР-23, ХААТР-24/-ыг өөрчлөх
- Мөн засаг захиргааны нэгжийн зохион байгуулалтыг шинэчлэх, 4 аймаг, 2-5 үндсэн хотуудыг зохион байгуулах, чөлөөт бүсүүдийг дэмжих хэрэгтэй.
- Хот, хөдөөгийн орлогын ялгааг, улмаар хаана суурьшлыг бий болгохоос шалтгаалан нийгэм эдийн засгийн нөхцөл бололцоог нь дээшлүүлэх зорилт тавьж байна.
- Нийгэм эдийн засгийн бодлогод хүн амын байршилт шилжих хөдөлгөөний талаар тусгахдаа аль болох далд механизмаар явагдах боломжийг олгож байх нь зүйтэй.
- Хүн амын байршилт, дотоодын шилжих хөдөлгөөн ба нийгэм эдийн засгийн харилцан нөлөөллийг тодруулах зорилгоор судалж үзлээ.
- Хүн амын байршилт, шилжих хөдөлгөөнийг судлах арга аргачлалуудыг тодруулан өөрийн судалгаанд ашиглах болмжуудыг нь мэдээлэлтэйгээ харьцуулан авч үзэх.
- Хүн амын байршилт, дотоод шилжих хөдөлгөөний тоон мэдээллийн эх үүсвэрүүдийн талаар ямар түвшинд мэдээлэл цуглуулагдаж хэрхэн шинжилгээ хийгдэж байна вэ? . Ямар шинжилгээнүүдийг хийх боломжтой вэ, ямар үр дүнд хүрэх вэ гэдгийг тодруулах
- Монгол улсын хүн амын байршилт, дотоод шилжих хөдөлгөөний өнгөрсөн үе болон өнөөгийн үеийн чиг хандлагыг нийгэм эдийн засгийн харилцан нөлөөлөлүүдийг гарган харах
- Хүн амын байршилт, дотоод шилжих хөдөлгөөн ба нийгэм эдийн засгийн харилцан нөлөөллийг хялбар загвараар тодорхойлох,
- Хүн амын байршилт, дотоод шилжих хөдөлгөөнийг нийгэм эдийн засгийн нөхцөл байдалд зөв зохицуулах удирдах боломжийг таамаглах гэсэн зорилт юм.

Дээрх зорилтуудын дагуу судлах болсон шалтгааныг тодруулахад :

Манай орны хувьд газар нутагтайгаа харьцуулахад хөдөлмөрийн нөөцийн хувьд дутагдалтай байгаа өнөөгийн нөхцөлд хүн амын байршилтыг зөв зохицуулах улмаар нэгэнт бий болсон хөдөлмөрийн нөөцийг бүрэн ашиглахад шилжих хөдөлгөөний гүйцэтгэх үүрэг их юм. Гэтэл хүн амын байршилт, дотоод шилжих хөдөлгөөн өнгөрсөн хугацаанд хэрхэн явагдаж байсан одоо цаашид ямар арга замаар зохицуулах нь зүйтэй вэ гэдэгт хариулт өгөх хэрэгтэй гэж үзсэн.

Дээрх зорилтуудын дагуу судалсаны эцэст тэмдэглэхэд:

Өнгөрсөн хугацаанд дотоод шилжих хөдөлгөөний нөлөөлөл (төрөлт нас баралтыг бодвол) бага байсантай холбогдон энэ талаар бага судалсан. Мөн мэдээллийг цуглуулж буй зорилгоосоо шалтгаалан (иргэний хаягийн бүртгэлийг цагдаагийн байгууллагын зориулалттай) шинжилгээ хийх, хүн амын талаарх бодлогод шууд авч ашиглахад боломж муутай юм.

Нэгэнт бий болсон хөдөлмөрийн нөөцийг, хүн амын зохистой байршилтыг буй болгох замаар үр ашигтай ашиглах нь хэрэгтэй юм. Үүнд, хүн амын дотоод шилжих хөдөлгөөнийг зөв зохицуулах шаардлага зүй ёсоор тавигдана.

Дээрх шалтгаануудын улмаас хүн амын байршилт, дотоод шилжих хөдөлгөөнийг одооноос анхааран судалж мэдээллийг нь сайжруулан, аливаа бодлогыг хэрэгжүүлэхдээ хүн амын байршилт, дотоод шилжих хөдөлгөөнийг хэрхэн өөрчилж болохыг судалж, хүн амын байршилтыг аль болох зөв зохистой байдлыг нь харгалзан үзэх хэрэгтэй.